



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/1677

Хэрлэн сум

Сургалт зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарь, төлөвлөгөөний дагуу аймгийн Онцгой комисс, аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, томилгоот бүүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах менежментийн болон иргэд, олон нийтийг аюулгүй амьдрах ухаанд сургаж дадлагажуулах зорилгоор зохион байгуулагдах аймгийн иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулагдахтай холбогдуулан аймгийн 18 сум 5 тосгоны Засаг дарга, захирагч нарт команд штабын сургалтыг зохион байгуулахад шаардагдах 12,971,000 (арван хоёр сая есөн зуун далан нэгэн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Сургалтад шаардагдах материал, хоолны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3. Сумдын удирдлагуудад заагдах сургалтын үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, (Хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 25 -ний өдрийн
АБЧД дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Хоолны зардал	60	12.000.000
2	Сургалтын материал	3	491.000
3	Бичиг хэргийн материал	60	480.000
Нийт			12.971.000